

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	11	13	Удирдлагын академийн төрийн албанд томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад Спортын хэлтсийн дарга Б.Гансүх, Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ганбат нарыг хамруулсан. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөн, Биеийн тамир, спортын салбарын 100-н жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, баруун бүсийн сургалт, Төрийн албаны зөвлөл, Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага солилцох арга хэмжээ, ажлын байран дахь сургалт зэрэгт нийт 20 гаруй арга хэмжээнд байгууллагын 21 албан хаагчийг хамруулсан.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	6	10	
			Мэргэшүүлэх сургалт	1	1	
			Туршлага солилцох арга хэмжээ	3	3	
			Бусад	1	1	
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	20	21	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	7	7	
			Эрэгтэй албан хаагч	13	14	
			Удирдах албан тушаалтан	3	3	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	18	18	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	95	100			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	2	4	Биеийн тамир, спортын газрын Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ганбатыг 2024 оны 04 сарын 19-24-ны хооронд БНХАУ-ын Бээжингийн Спортын Их сургуульд Спортын салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад, Спортын хэлтсийн дарга Б.Гансүхийг шүүгчийн зэрэг ахиулах шалгалтанд хамруулах зорилгоор Солонгос улсад зохион байгуулагдсан “Korea open” тэмцээнд шүүгчээр ажиллуулсан бол, Монголын үндэсний Олимпийн хорооноос зохион байгуулсан сургалтанд Сагсан бөмбөгийн дасгалжуулагч Б.Батбаасанг Хөх хотод чадавхжуулах, туршлага солилцох сургалтад, Самбо, жүдо бөхийн дасгалжуулагч Д.Баянмөнхийг олон улсын тэмцээн уралдаанд оролцох, туршлага судлах, хөгжүүлэх, аймгийн спортын амжилтыг
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	2	4	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	0	0	
			Эрэгтэй албан хаагч	2	4	
			Удирдах албан тушаалтан	0	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	2	3	
		2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20	18.18	

						дээшлүүлэх зорилгоор 3 удаа гадаад руу тэмцээн уралдаанд явуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	2.0	6.5	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хорооноос 2024 оны 04 дүгээр сарын 24-29-ны хооронд БНХАУ-ын Бээжин хотын Бээжингийн Спортын Их сургуультай хамтран зохион байгуулсан "Спортын салбарын албан хаагчдыг чадавхжуулах" сургалтад Завхан аймгийн Биеийн тамир, спортын газрын Тогтоол шийдвэр, тайлан мэдээ хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Г.Ганбатыг хамруулж байгууллагаас замын зардал болох 890,000 мянган төгрөгийг шийдвэрлэж өгсөн. 2024 оны байдлаар Биеийн тамир, спортын газрын 1 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж 4 албан хаагч төрийн албаны тусгай шалгалт өгч жинхлэн томилогдсон байна.
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	4.5%	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	8	8	Байгууллагын албан хаагчдад ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, хоолны зардлыг хоногт 20,000 төгрөгөөр тооцон холбогдох хууль тогтоомжийн дагуу олгон цалин урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	20,000	20,000	
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	85	85	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг хангах, иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган биеийн тамир, спортын газрын заалны шалыг стандартад нийцүүлэн шинэчилж агч модон шалтай болсон. Мөн байгууллагын өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан халаалтын паарыг шинэчилсэн. 2 албан хаагчыг суурин компьютер, ноутбүүкээр хангаж ажилласан.
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1	1	2023 оны 06 дугаар сарын 14 нд бүх ажилчдыг Нэгдсэн эмнэлэгт үзлэгт хамруулсан. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа Эрт илрүүлэг арга хэмжээнд нийт ажилчдыг өрхийн эмнэлгээр хамруулсан. 2024 оны байдлаар 5 албан хаагчыг ахин эрт илрүүлэгт хамруулж эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай албан хаагчдад цалинтай чөлөө олгож эрүүл мэндийг хамгаалах урьдчилан
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	15	12	

						сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	1.5	1.9	Байгууллагын гэр болон галлагаатай байшинд амьдардаг, өрх толгойлсон, олон хүүхэдтэй 4 албан хаагчид тус бүр 485,000 нийт 1,940,000 төгрөгийн түлээний хөнгөлөлтийн тэтгэмж олгосон.

ТАЙЛАГНАСАН:
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН
АРГА ЗҮЙЧ Г.ГАНБАТ

ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА М.БАТБАЯР